

Разолтан 50 мг бүрхүүлтэй шахмал

Losartan potassium

Бүртгэлийн дугаар №

Найрлага: Үйлчлэгч бодис: Лозартан кали 50 мг

Туслах бодис: маннитол, бичил талст целлюлоза, натрийн кроскармеллоза, повидон К – 30, магнийн стеарат

Бүрхүүлийн найрлаганд: гипромеллоза, титанийн диоксид (E171), тальк, пропиленгликоль.

Эмийн хэлбэр:

Бүрхүүлтэй шахмал

Фармакологийн үйлдэл:

Ангиотензин II рецепторыг хориглох бэлдмэлийн бүлэгт хамаарна. Ангиотензин II нь бие махбодын дотор агуулагдаж, цусны судасны рецепторт хориг үүсгэснээр судасыг нарийсгаж цусны даралтыг ихэсгэдэг бодис юм.

Лозартан нь ангиотензин II-ыг судасны ханын рецептортой харилцан үйлчлэх боломжийг алдагдуулан судсыг өргөсгөж цусны даралтыг бууруулдаг эмийн бэлдмэл юм.

Лозартаны бас нэг гайхамшигтай үйлчилгээ нь чихрийн шижингийн 2-р хэлбэрийн үеийн цусны даралт ихсэлтээс бөөрний үйл ажиллагаанд гарах өөрчлөлтийг саатуулдагт оршино.

Хэрэглэх заалт:

- Цусны даралт ихсэх өвчний эмчилгээнд
- Чихрийн шижингийн 2-р хэлбэрийн үед цусны даралт ихэссэн өвчтөнд (лабораторын шинжилгээгээр бөөр гэмтсэн ба протеинури $\geq 0,5$ г/хоногт) шээсээр уураг алдаж байгаа үед бөөрний гэмтлийг эмчлэх зорилгоор
- Зүрхний архаг дутагдлын үед тус тус хэрэглэнэ.
Хэрэв АХФ-ийн идэвхийг саатуулагч эм зохимжгүй гэж эмч үзэж байгаа үед лозартаныг сонгоно. Харин АХФ-ийн идэвхийг хориглогч эм хэрэглэсэн үед зүрхний дутагдлаас гарч байгаа бол лозартаныг хэрэглэх шаардлагагүй .
- Цусны даралт ихтэй, тэр тусмаа зүрхний зүүн ховдлын хана зузаарсан үед лозартан хэрэглэхэд тархинд цус харвах эрсдлийг илэрхий бууруулдаг болох нь судалгааны үр дүнд нотлогджээ.

Бэлдмэлийг хэрэглэхээс өмнө зайлшгүй мэдэх мэдээлэл:

Цээрлэлт:

- Хэрвээ лозартанд эсвэл түүний найрлаганд орсон туслах бодист мэдрэг бол
- 3 хүртэлх сартай жирэмсэн эхэд

- Элэгний илэрхий хүнд дутагдалтай хүнд тус тус хэрэглэхийг хориглоно.

Онцгой анхааруулга!

Дараах тохиолдолд Разолтаныг хэрэглэхээс өмнө эмчдээ мэдэгдэнэ.

- Урьд нь ямар нэг эм хэрэглэхэд нүүр, уруул, хэл, хоолой, хавагнаж байсан бол
- Хүчтэй бөөлжүүлж, суулгаж байгаа үед
- Шээс хөөх эм хэрэглэж байгаа, давсны хэрэглээ хязгаарласан өвчтөнд
- Бөөрний артерийн судасны нарийсал эсвэл бөөр шилжүүлэн суулгах мэс заслын дараахи эрт үе
- Элэгний үйл ажиллагааны гүнзгий алдагдал
- Бөөрний хүнд өвчин, гэмтэл эсвэл амь насанд халгаатай зүрхний хэм алдагдлын улмаас зүрх дутагдлын шинж илэрч байгаа үед
- Зүрхний хавхлагийн ба булчингийн гэмтэл
- Зүрхний цусан хангамжын дутагдалд хүргэдэг титэм судасны өвчин эсвэл тархины цусан хангамжын дутагдалд хүргэдэг тархины судасны өвчин
- Гиперальдостронизм
- Жирэмсэн эсвэл жирэмслэхээр төлөвлөж байгаа үед

Эмийн ба бусад харилцан үйлчлэл:

Даралт бууруулах үйлдэлтэй бусад бэлдмэлүүдтэй хавсран хэрэглэхэд цусны даралт огцом бууж болно. 3 цагирагт антидепрессант, солиорлын эсрэг бэлдмэл баклофен, амифостин зэрэг эмүүдтэй хавсруулан хэрэглэхэд бас даралт багасч болно. Бие махбодид калийн хуримтлал үүсгэдэг эм эсвэл кали агуулсан эм хүнсний нэмэлт кали хадгалагч эм (амилорид, триамтерен спиронолактон, гепарин) тэй хавсруулан хэрэглэхэд организм дахь калийн түвшинг нэмэгдүүлж болзошгүй.

Үрэвслийн эсрэг стероид бус бэлдмэл (индометацин ба ЦОГ-2 ын эсрэг бэлдмэл) -тэй хавсруулан хэрэглэхэд лозартаны цусны даралт бууруулах үйлдлийг багасгаж болно. Эдгээр эмийг элэгний үйл ажиллагааны дутагдалтай хүнд хавсруулан хэрэглэхэд өвчтөний биеийн байдал дордож болзошгүй.

Лити агуулсан эмийн бэлдмэлтэй лозартаныг эмчийн хяналтгүйгээр хавсарч хэрэглэж болохгүй.

Тусгай бүлэг өвчтөнд зориулсан онцгой болгоомжлол!

Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ:

Жирэмсэн эсвэл жирэмслэх төлөвлөгөөтэй байгааг эмч заавал тодруулж байх ёстой. Хэрэв хэрэглэж байгаа бол зогсоох хэрэгтэй. Жирэмсний эхний хагаст Разолтаныг хэрэглэхгүй. Жирэмсний 2 дахь 3 сард Разолтан ургийн хөгжилд нөлөөлдгийг анхаарах хэрэгтэй.

Хүүхэд хөхүүлж байгаа эсвэл хөхүүлэхээр завдаж байгаа эхэд болгоомжтой хандах ёстой. Хэрэв хөхүүл эх хүүхдээ хөхөөр хооллохыг хүсэж байгаа бол эмч өөр эм сонгож хэрэглэх эсвэл нярай хүүхдийг тэжээлд оруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

Хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрэглэх:

Хүүхдэд Разолтаны хэрэглээ нилээд судлагдсан. Хүүхдийн өсөлт хөгжилтөнд сөрөг нөлөөгүй.

Автомашин жолоодох болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:

Яг энэ чиглэлээр хийсэн судалгаа байхгүй. Разолтан техник удирдах, ажиллах чадварыг багасгах шинж чанар байхгүй. Даралт ихтэй хүнд хэрэглэхэд даралт багассанаас толгой эргэх, нойрмоглох шинж гарч болно. Ийм тохиолдолд эмчдээ хандаж зөвөлгөө авах хэрэгтэй.

Бэлдмэлийг зөв хэрэглэхтэй холбоотой мэдээлэл:

Хэрэглэх арга, тун:

Шахмалыг аяга усаар даруулж ууна. Хоногийн тунг хоногт нэг удаа хэрэглэх нь зохимжтой. Эмчлэгч эмчийн зааврыг нарийн баримтлан хэрэглэнэ. Разолтаны уух хугацаа хоол хэрэглэх хугацаатай хамааралгүй.

- Цусны даралт ихтэй өвчтөнд голдуу 50 мг-р хоногт 1 удаа хэрэглэж эмчилгээг эхэлдэг. Эмчилгээний төгс үр дүнд 3-6 долоо хоногийн дараа хүрнэ. Зарим өвчтөнд шаардлагатай гэж үзвэл хоногийн тунг 100 мг хүртэл нэмж болно. Хэрэв лозартаны эмчилгээний үр дүн хэтэрхий хүчтэй, эсвэл сул санагдвал эмчдээ хандаж зөвөлгөө авна.
- Чихрийн шижингийн 2-р хэлбэр ба цусны даралт ихдэх өвчтэй хүнд: Эмчилгээг 50 мг-р хоногт нэг удаа хэрэглэж эхэлнэ. Цаашид хоногийн тунг 100 мг хүртэл нэмж болно. Лозартаныг цусны даралт багасгах үйлчилгээтэй бусад эм (шээс хөөх эм, кальцийн антагонист, альфа ба бета блокатор, төвийн үйлдэлтэй эмүүд) ба инсулин, сульфаниламочевины бүлгийн эмүүд, глитазон ба глюкозидазын идэвхи багасгах эм зэрэгтэй хавсруулан хэрэглэж болно.
- Зүрхний дутагдалтай өвчтөн: Ерөнхийдөө 12,5 мг-р хоногт нэг удаа ууж эхэлнэ. Тунг долоо хоногийн зайтайгаар 25 мг, 50 мг хүртэл нэмэгдүүлнэ. Барих тун 50 мг/хоногт.

Зүрхний дутагдлын эмчилгээнд Разолтаныг шээс хөөх эм, хуруувчин цэцгийн бэлдмэл, бетаблокатортай хавсран хэрэглэнэ.

Тусгай бүлэг өвчтөнд зориулсан анхааруулга!

Зарим өвчтний хувийн онцлог, бөөрний үйл ажиллагааны алдагдал, шээс хөөх эм их тунгаар хэрэглэж байгаа өндөр настай хүмүүс зэрэгт лозартаныг харьцангуй бага тунгаар хэрэглэх нь зохимжтой. Бөөрний хүнд өвчтэй хүнд Разолтан хэрэглэхгүй. Хэрэв нэг удаагийн уух эмийг мартсан бол маргаашийн уух цагт эмээ хэрэглэнэ. Эмийнхээ тунг давхцуулан ууж болохгүй.

Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө:

Тун хэтэрсний улмаас даралт хэт багасах, зүрх дэлсэх, зүрхний хэм түргэсэх болон цөөрөх шинж илэрч болзошгүй. Энэ үед шинж тэмдгийн эмчилгээ хийхээс гадна ходоодыг угаана.

Гаж нөлөө: Хэрэв хүнд харшлын урвалын шинж /тууралт, загатнаа, нүүр, хэл уруул, хоолой хавагнах/ илэрвэл лозартаныг зогсоож эмч болон ойролцоох эмнэлэгт хандана.

Ийм шинж тэмдэг 10000 хүнд 1 тохиолддог бөгөөд энэ үед эмнэлгийн яаралтай тусламж хэрэгтэй.

Гаж нөлөөг илрэх байдлаар нь:

Маш элбэг $>1/10$ буюу их

Элбэг $>1/100$ буюу $<1/10$

Хааяа $>1/1000$ буюу $<1/100$

Ховор $>1/10000$ буюу $<1/1000$

Маш ховор $<1/10000$

Элбэг тохиолдох гаж нөлөө: Толгой эргэх, даралт багасах, цусны сахар багасах, гиперкалиеми болгох.

Хааяа тохиолдох гаж нөлөө: нойрмоглох, толгой өвдөх, зүрх дэлсэх, нойр хямрах, цээжээр өвдөх /бах маягийн өвдөлт/, даралт багасах, ялангуяа шингэн алдсан болон шээс хөөх эм хэрэглэж байгаа үед, тун хамааралт ортостатик нөлөө, амьсгал бачуурах, хэвлийгээр өвдөх, бөөлжих, загатнах, өтгөн хатах, чонон хөрвөс.

Ховор тохиолдох гаж нөлөө: Судаслаг хаван/ васкулит, Шенлейн - Генох/, гар хөл бадайрах, сулрах, түр зуур ухаан балартах, зүрхний хэм түргэсэх/ тосгуурийн жирвэгнээ/, тархинд цус харвах, элэгний ферментийн идэвхи ихсэх боловч эмээ зогсооход буурна.

Маш ховор тохиолдох гаж нөлөө: Цусны улаан эсийн тоо цөөрөх, тромбоцитын тоо буурах, мигрень, ханиах, элэгний өөрчлөлт, булчин үе мөчөөр өвдөх, томуу тест өөрчлөлт үүсэх, цусанд мочевины хэмжээ нэмэгдэх, цусны сийвэнгийн креатинин ба зүрхний дутагдалтай өвчтөнд калийн хэмжээ ихсэх, ууц нуруугаар өвдөх.

Савлалт: 10 бүрхүүлтэй шахмалыг блистертэй гаргах бөгөөд 3 блистерийг хэрэглэх зааврын хамт цаасан хайрцганд савлана.

Хадгалалт: + 25°C хүртэл хэмд, хүүхэд хүрэхээргүй газар хадгална.

Хадгалах хугацаа: Үйлдвэрлэснээс хойш 3 жил.

Эмийн сангаас олгох журам: Жороор олгоно.

Үйлдвэрлэгч: Балканфарма - Дупница АД, Самоковское шоссе № 3, 2600, Дупница, Болгар.